



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/50

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 28 дугаар зүйлийн 28.7.2, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/75 дугаар захирамж, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Улс орон даяар өвөлжилт хүндэрч, зудын эрсдэлт нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд малчдад олгох тусламжийн ажилд 600,000 (зургаан зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Тусламжийн ажилд шаардлагатай жижиглэн савлах шуудайнд зарцуулагдах 600,000 (зургаан зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох хууль, журмын дагуу баримт бичгийн бүрдлийг хангаж, гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА